

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/027/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Амармэнд

Утас: 70453799, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
 - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
 - 3.5.3 Нэмэлт төсөв

4. АУДИТЫН ТАЙЛАН

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
 - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.5.1 Завсрын аудитын талаар
 - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН
ДАРГА Т.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

2026.02.05 № УВА-2026/027/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050082

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,726,386.26	10,083,487.00
33	АВЛАГА	59,399.26	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	59,399.26	-
33300	Татаас санхүүжилтийн авлага		3,181,700.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,666,987.00	6,901,787.00
354	Хангамжийн материал	4,666,987.00	6,901,787.00
35420	Аж ахуйн материал	2,374,487.00	5,539,287.00
35440	Түлш, шатах тослох материал	1,140,000.00	210,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,152,500.00	1,152,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	134,054,939.28	133,890,315.49
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	134,054,939.28	133,890,315.49
392	Биет хөрөнгө	132,554,939.28	132,390,315.49
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,500,000.00	67,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,000,000.00)	(7,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,641,489.96	52,391,489.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,508,084.67)	(21,905,810.26)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,568,989.00	39,568,989.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,127,455.01)	(14,164,353.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,800,000.00	19,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,320,000.00)	(3,300,000.00)
393	Биет бус хөрөнгө	1,500,000.00	1,500,000.00
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	138,781,325.54	143,973,802.49
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	3,181,700.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,181,700.00
413	Өглөг	-	3,181,700.00
4136	Бусад өглөг	-	3,181,700.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,596,700.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	1,585,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	138,781,325.54	140,792,102.49
51	Засгийн газрын хувь оролцоо	138,781,325.54	140,792,102.49
512	Хуримтлагдсан үр дүн	138,781,325.54	140,792,102.49
51210	Өмнөх үеийн үр дүн	30,854,948.12	138,781,325.54
51220	Тайлант үеийн үр дүн	107,926,377.42	2,010,776.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	138,781,325.54	143,973,802.49

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	828,183,800.00	641,591,770.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,620,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	70,620,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	70,620,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	757,563,800.00	641,591,770.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	488,470,900.00	580,987,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	488,470,900.00	580,987,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	269,092,900.00	60,603,870.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,092,900.00	36,207,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	215,000,000.00	24,395,970.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	720,257,422.58	639,580,993.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	720,257,422.58	639,580,993.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,109,384.45	571,759,264.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,008,090.86	423,815,296.82
210101	Үндсэн цалин	187,942,460.86	256,421,009.82
210102	Нэмэгдэл	78,934,130.00	113,898,487.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,450,000.00	16,665,000.00
210104	Урамшуулал	26,681,500.00	36,830,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,368,811.75	55,539,573.55
210201	Тэтгэврийн даатгал	27,566,655.13	38,225,172.74
210202	Тэтгэмжийн даатгал	3,251,680.89	4,492,940.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,579,640.95	2,136,910.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,579,640.45	2,136,910.24
210205	Эрүүл мэндийн даатгал	6,391,194.33	8,547,640.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,000,000.00	6,000,000.00
210304	Байрны түрээс	6,000,000.00	6,000,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	45,201,060.00	20,020,170.00
210401	Бичиг хэрэг	11,195,500.00	2,332,900.00
210402	Тээвэр, шатахуун	4,860,000.00	7,150,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,065,160.00	3,359,670.00
210404	Ном, хэвлэл	12,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,080,400.00	7,177,600.00
2107	Томилолт, зочны зардал	16,389,000.00	1,998,800.00
210702	Дотоод албан томилолт	16,389,000.00	1,998,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,284,000.00	44,452,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,520,000.00	43,408,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	604,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182,858,421.84	19,932,623.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	167,013,200.00	18,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,845,221.84	19,914,623.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,148,038.13	71,003,428.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,023,762.60	1,808,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,738,762.60	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,285,000.00	1,808,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	86,124,275.53	66,013,360.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,124,275.53	66,013,360.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	107,926,377.42	2,010,776.95
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	107,926,377.42	2,010,776.95

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	757,563,800.00	641,591,770.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	757,563,800.00	641,591,770.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	488,470,900.00	580,987,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	488,470,900.00	580,987,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	269,092,900.00	60,603,870.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	54,092,900.00	36,207,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	215,000,000.00	24,395,970.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	706,048,800.00	621,841,770.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	706,048,800.00	621,841,770.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	600,900,761.87	550,838,341.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	308,260,996.08	423,835,239.17
210101	Үндсэн цалин	188,666,000.72	256,259,260.82
210102	Нэмэгдэл	78,685,790.36	114,241,793.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,450,000.00	16,665,000.00
210104	Урамшуулал	26,459,205.00	36,669,185.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,175,305.79	55,460,231.94
210201	Тэтгэврийн даатгал	27,287,382.19	38,106,231.13
210202	Тэтгэмжийн даатгал	3,231,880.89	4,492,940.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,609,340.45	2,143,510.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,609,340.45	2,143,510.24
210205	Эрүүл мэндийн даатгал	6,437,361.81	8,574,040.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,000,000.00	5,974,900.00
210304	Байрны түрээс	6,000,000.00	5,974,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,711,660.00	15,231,370.00
210401	Бичиг хэрэг	6,398,900.00	2,053,700.00
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	6,220,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,065,160.00	2,843,770.00
210404	Ном, хэвлэл	12,000,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,247,600.00	4,113,900.00
2107	Томилолт, зочны зардал	16,389,000.00	1,998,800.00
210702	Дотоод албан томилолт	16,389,000.00	1,998,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,479,600.00	48,337,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,715,600.00	47,733,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	604,800.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,884,200.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	166,398,200.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	486,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	105,148,038.13	71,003,428.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,023,762.60	1,808,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,738,762.60	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,285,000.00	1,808,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	86,124,275.53	69,195,428.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	86,124,275.53	69,195,428.89
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	51,515,000.00	19,750,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	51,515,000.00	19,750,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,515,000.00	19,750,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	51,515,000.00	19,750,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,515,000.00	19,750,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(51,515,000.00)	(19,750,000.00)

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	30,854,948.12	0.00	30,854,948.12
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	30,854,948.12	0.00	30,854,948.12
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	107,926,377.42	0.00	107,926,377.42
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	138,781,325.54	0.00	138,781,325.54
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	138,781,325.54	0.00	138,781,325.54
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	138,781,325.54	0.00	138,781,325.54
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,010,776.95	0.00	2,010,776.95
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	140,792,102.49	0.00	140,792,102.49

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	606,410,300.00	511,792,839.46	94,617,460.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	606,410,300.00	511,792,839.46	94,617,460.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	604,602,300.00	509,984,839.46	94,617,460.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	469,339,100.00	405,719,509.68	63,619,590.32
210101	Үндсэн цалин	267,799,500.00	256,259,260.82	11,540,239.18
210102	Нэмэгдэл	128,746,200.00	96,126,063.86	32,620,136.14
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,070,000.00	16,665,000.00	21,405,000.00
210104	Урамшуулал	34,723,400.00	36,669,185.00	(1,945,785.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,773,200.00	53,198,259.78	5,574,940.22
210201	Тэтгэврийн даатгал	39,982,500.00	36,568,090.16	3,414,409.84
210202	Тэтгэмжийн даатгал	4,703,500.00	4,311,982.36	391,517.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,347,900.00	2,053,031.27	294,868.73
210204	Ажилгүйдлийн даатгал	2,347,900.00	2,053,031.27	294,868.73
210205	Эрүүл мэндийн даатгал	9,391,400.00	8,212,124.72	1,179,275.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,975,000.00	5,974,900.00	100.00
210304	Байрны түрээс	5,975,000.00	5,974,900.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,064,100.00	7,665,570.00	5,398,530.00
210401	Бичиг хэрэг	5,979,000.00	2,053,700.00	3,925,300.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,500,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,590,600.00	2,843,770.00	746,830.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,994,500.00	1,268,100.00	726,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,000,000.00	19,750,000.00	250,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,750,000.00	250,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,998,800.00	1,998,800.00	-
210702	Дотоод албан томилолт	1,998,800.00	1,998,800.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,452,100.00	15,677,800.00	19,774,300.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,419,000.00	15,073,000.00	19,346,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	898,700.00	604,800.00	293,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,600.00	-	89,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,800.00	-	44,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,808,000.00	1,808,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,808,000.00	1,808,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,808,000.00	1,808,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	606,410,300.00	511,792,839.46	94,617,460.54
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	606,410,300.00	511,792,839.46	94,617,460.54
131001	Улсын төсвөөс санхүүжих	606,410,300.00	511,792,839.46	94,617,460.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.0	0.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	35.00	(35.00)
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	1.00	(1.00)
610001	Төсвийн байгууллага	-	1.00	(1.00)
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	17.00	(17.00)
620001	Удирдах ажилтан	-	1.00	(1.00)
620002	Гүйцэтгэх ажилтан	-	13.00	(13.00)
620003	Үйлчлэх ажилтан	-	3.00	(3.00)
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	17.00	(17.00)
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	-	14.00	(14.00)
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	3.00	(3.00)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,603,501.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	60,603,501.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,603,501.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,115,729.49
210102	Нэмэгдэл	18,115,729.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,261,972.16
210201	Тэтгэврийн даатгал	1,538,140.97
210202	Тэтгэмжийн даатгал	180,957.75

210203	ҮОМШӨ-ний даатгал	90,478.97
210204	Ажилгүйдлийн даатгал	90,478.97
210205	Эрүүл мэндийн даатгал	361,915.50
2104	Хангамж, бараа материалын зардал	7,565,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,720,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,845,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,660,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,660,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	60,603,870.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	60,603,870.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	36,207,900.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,395,970.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол үндэсний болон дэлхийн сонгодог уран бүтээлийг мэргэжлийн өндөр түвшинд туурвих, иргэдийн авьяас билгийг нээн хөгжүүлэх, бүх нийтийн соёлын боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээнд судалгаа инновацын үйл ажиллагааг эрчимжүүлж иргэдэд хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар соёл, урлагийн үйлчилгээг үзүүлэх, харьяалах нутаг дэвсгэрийнхээ соёл урлагийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр Соёлын талаар баримталж буй бодлогыг орон нутгийн хэтийн төлөвтэй уялдуулан үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн

тогтоосон.

- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,192.5 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	
Авлага	59.4	3,181.7	3,122.3
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	4,666.9	6,901.8	2,234.9
Үндсэн хөрөнгө	134,054.9	133,890.3	-164.8
Нийт хөрөнгө	138,781.3	143,973.8	5,192.5
Өр төлбөр	0.0	3,181.7	3,181.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	138,781.3	137,610.4	-1,170.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	138,781.3	140,792.1	2,010.8

Авлага дансны үлдэгдэл 3,122.3 мянган төгрөг байгаа нь татаас санхүүжилтийн авлага бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,901.8 мянган төгрөг болж 2,234,9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь 133,890.3 мянган төгрөг болж 164.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 19,750.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж худалдан авсан, тайлант онд 19,914.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 3,181.7 мянган төгрөг болж 3,181.7 мянган төгрөгөөр өссөн нь зардлын дансны гүйлгээний эрх хязгаарласантай холбоотой өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 137,610.4 мянган төгрөг болж 1,170.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газрын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 577,109.1 мянга, нийт зарлагыг 577,109.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 33,841.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 610,950.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 4,540.4 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 606,410.2 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 580,987.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 580,987.9 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь зарим зардлын гүйлгээний эрх хязгаарласан болон цалин, шитгэлийн зардлын хэмнэлтийн хүрээнд 69,195.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71704-Соёл урлаг, 80101-Үйл ажиллагааны зардал	573,182.2	567,105.8	6,076.4	98.9%
2	71704-Соёл урлаг, 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,808.0	1,808.0	-	100%
3	71704- Соёл урлаг, 81569- Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	31,420.0	12,074.0	19,346.0	38.4%
	Нийт	606,410.3	580,987.9	25,422.4	95.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	0.0	Dynamic
2	Унаа, хоолны зардал	16,665.0	2025 онд 16,665.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар	0.0	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь сургалт семинартай холбоотой зардал гараагүй байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	0.0	Хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зардал гараагүй байна.
7	Орон тоо	405,719.5	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь 2025 онд 15 орон тоо ажиллахаар батлагдсанаас 12 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын нэмэлт нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 24,395.9 мянган төгрөг, ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 36,207.9 мянган төгрөг нийт 60,603.8 мянган төгрөгийн орлого хүлээн авч зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Соёл урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай бараа материал болон хөрөнгө худалдан авахад 39,286.6 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 720,257.4 мянган төгрөгийн 1 хувиар буюу 7,202.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 642,762.7 мянган төгрөгийн 1 хувиар буюу 6,427.6 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 5,142.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Дүн										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн										

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2026 оны 02 сарын 04-ний өдөр